



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ДУНДГОВЬ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,
Сайнцагаан сум, Нарлаг баг
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08
E-mail: dundgovi@audit.gov.mn

2016.11.04 № 01/158

ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Б.ОЮУНТӨГС ТАНАА

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 203 дугаар тушаалаар баталсан “Санхүүгийн тайлангийн аудитын журам”-ын 1.9, аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Цагаандэлгэр сумын ерөнхий боловсролын сургуулийн 2016 оны 3 дугаар улирлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар нийт 316,277,422.00 /Гурван зуун арван зургаан мянга хоёр зуун далан долоо дөрвөн зуун хорин хоёр/ төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Ээлжийн амралтын олговор тооцохдоо нэг өдрийн дундаж цалин хөлсийг буруу тодорхойлсноос 6 ажилтанд нийт 62,397.00 төгрөгийг дутуу олгосон.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2003 оны 166-р тушаалын 2-р хавсралтын 4-т /Ээлжийн амралтын олговрыг тодорхойлохдоо амралт олгохын өмнөх 12 сарын цалин хөлсний нийлбэрийг 12-т хувааж нэг сарын дундаж цалин хөлсийг гаргах бөгөөд гарсан тоог байгууллага, нэгжид мөрдөж буй ажлын өдрийн тоонд хувааж нэг өдрийн дундаж цалин хөлсийг тооцож гаргана. Нэг өдрийн дундаж цалин хөлсийг ажилтны ээлжийн амралтын өдрөөр үржүүлэн ажилтанд олговол зохих ээлжийн амралтын олговрын хэмжээг тодорхойлно./

2. Холбогдох стандарт, заавар журмыг мөрдөөгүйгээс 563,500.00 төгрөгийн бараа материалын дансны ангилал буруу бүртгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.16-д /Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг мөрдөнө./

3. Их засварыг капиталжуулж бүртгээгүйгээс 315,651,525.00 төгрөгийн хөрөнгийг буруу тайлагнасан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 4.34-т /Үндсэн хөрөнгийн засварын зардал нь үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг уртасгах гэх мэт уг хөрөнгөөс хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлж байвал уг зардлыг капиталжуулан үндсэн хөрөнгийн анхны өртгийг нэмэгдүүлнэ. Бусад тохиолдолд тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө./

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.1-д /Нягтлан бодох бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох

1000000712


стандарт, журам, шаардлагын дагуу зохих ёсоор хөтлөөгүй / заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. Ээлжийн амралтын олговрыг тооцоохдоо холбогдох дүрэм журмыг баримталж, дундаж цалинг зөв тооцож байх,
2. Бараа материалыг зөв ангилаж дансанд бүртгэх
3. Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар их засварыг бүртгэсэн бичилтийг залруулах.
4. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2016 оны 12 дугаар сарын 01-ны дотор албан ёсоор ирүүлэхийг Цагаандэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал /Б.Оюунтөгс/, нягтлан бодогч /Б.Цэндмаа/ нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН¹:

Шинжээч



ЗӨВШӨӨРСӨН:

Цагаандэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль:

Захирал

Б.Оюунтөгс

Нягтлан бодогч

Б.Цэндмаа

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.